



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 10 сарын 21 өдөр

Дугаар А/555

Мөрөн сум

Дэмжлэг үзүүлэх тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит XXVIII хуралдааны XXVIII/37 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хөвсгөл аймгийн иргэн, Жудо бөхийн Олон улсын хэмжээний мастер, Дэлхийн 2024 оны аварга, Парис-2024 зуны олимпын мөнгөн медальт тамирчин Бавуудоржийн Баасанхүүгийн анхны багш болох Алтанцэцэгийн Даваадорж, Бямбажавын Очирбат нарт тус бүр 10,000,000 (арван сая) төгрөг, нийт 20,000,000 (хорин сая) төгрөгийг олгосугай.

2.Тус зардлыг аймгийн “Засаг даргын Тамгын газар дансны Нийтийн биеийн тамирын зардал”-аас гаргаж зарцуулахыг ахлах нягтлан бодогч (Э.Анхцэцэг)-д үүрэг болгосугай.

3.Дээрх зардлыг зориулалтын дагуу зарцуулж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Э.Улам-Өсөх), захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс (Д.Цэцэгмаа)-т тус тус даалгасугай.

ДАРГА



П.ЛХАГВАЖАВ